

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2022 ОНЫ
ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2023-2024 ОНЫ
ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2022 он	2023 он	2024 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.0	5.0	6.0
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.7	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	15,771.7	17,168.9	18,880.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	33.7	33.0	32.2
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	18,158.8	19,040.7	20,523.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	38.8	36.6	35.0
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	2,410.5	881.9	1,483.2
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	5.2	1.7	2.5
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,387.1	-1,871.9	-1,643.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-5.1	-3.6	-2.8
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	<u>5,197.1</u>	5,569.3	6,124.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	<u>11.1</u>	10.7	10.4
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	31,439.4	32,727.2	34,839.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	67.2	62.9	59.4
9	Нийгмийн халамжийн тухай хуульд	490.4	530.0	569.6

	заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/			
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.0	1.0	1.0

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.55 дахь заалт:

“4.1.55.Ирээдүйн өв сангийн төсөв” гэж Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу бүрдүүлж, хуримтлал үүсгэх зорилгоор тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг;”

2/59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэг:

“59.7.Энэ хуулийн 59.1.2-т заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогын 5 хувийг, тухайн эх үүсвэрийн 20 ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх аймагт тэнцүү хэмжээгээр, 15 хувийг тухайн эх үүсвэрийн 1 ба түүнээс дээш 20 хүртэлх хувийг бүрдүүлэх аймагт бүрдүүлсэн хэмжээгээр нь хувь тэнцүүлж, мөн хуулийн 59.1.5-д заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогын 30 хувийг тухайн эх үүсвэрийн 1 ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх аймагт тэнцүү хэмжээгээр хуваарилна.”

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.6, 8.8, 8.9 дэх хэсэг, мөн зүйлийн 8.6.3 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.6.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтын “, Нийгмийн даатгалын сангийн төсөв” гэсний өмнө “Ирээдүй өв сангийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2 дахь заалтын “30” гэснийг “50” гэж, 60 дугаар зүйлийн 60.10 дахь хэсгийн“, 60.5” гэснийг “60.6” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.3 дахь заалтын “60.2.6”, “60.7” гэснийг, 60 дугаар зүйлийн 60.9 дэх хэсгийн “, 60.7” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.6 дахь хэсэг, мөн зүйлийн 59.1.1, 59.3.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.5, 60.7, 60.8 дахь хэсэг, мөн зүйлийн 60.2.2, 60.2.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.55 дахь заалт, 2 дугаар зүйлийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний

өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал, бусад зүйл, хэсэг, заалтыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг